

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2018 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
		НЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ САНАЛ, САНААЧЛАГА	
1.	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>1.1.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах.</p> <p>1.1.2. Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгжийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн, дүнг тооцох.</p> <p>1.1.3 ШШГЕГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын явц, биелэлт, үр дүнг байгууллагын цахим хуудаст тухай бүр нийтэлж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах.</p>	<p>ШШГЕГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлан, биелэлтийг 2018 оны 01, 03 дугаар улирлын байдлаар ШШГЕГ-ын даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, хэрэгжилтийг тооцон ажилласан. Мөн төлөвлөгөөг байгууллагын цахим хаягийн "Авлигын эсрэг үйл ажиллагаа" цэсэнд байршуулсан.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, хэлтэс, салбар нэгжүүдээс Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг 2018 оны улирал бүр нэгтгэсэн. 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 06/1115 дугаар албан бичгээр цаашид анхаарах асуудлаар үүрэг чиглэл өгч, жилийн эцсийн байдлаар авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги салбар нэгжийг дүгнэх шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож биелэлтийг хангаж ажилласан.</p> <p>Хяналт шалгалтын газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 06/404 дүгээр албан бичгээр Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг тухай бүр байгууллагын цахим хаягт нийтэлж ажиллах үүргийг ШШГЕГ харьяа аймаг, нийслэл дэх газар, хорих анги, хэлтэс салбар нэгжид хүргүүлж ажилласан ба Хяналт шалгалтын газраас 2018 онд Авлигын эсрэг үйл ажиллагаа цэсэнд цаг үеийн шинжтэй 6 удаагийн мэдээлэл байршуулсан.</p>
2.	<p>Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх</p>	<p>1.2.1 Албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар сургалт зохион байгуулах, АТГ-ын Олон нийтийн төвийн сургалтад албан хаагчдыг хамруулах.</p>	<p>АТГ-тай хамтран 2018 оны 01 дүгээр сард Говьсүмбэр аймаг дахь ШШГГ-425-р нээлттэй хорих анги, Орхон аймаг дахь ШШГГ-437-р нээлттэй хорих анги, Дорноговь, Булган аймаг дахь ШШГГ-ын эрх бүхий албан тушаалтан, мэдүүлэг гаргагч нарт, 2018 оны 01, 12 дугаар сард 401, 403, 405, 407, 409, 411, 415, 421, 429, 441-р хорих анги, Цагдан хорих 461-р анги, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Банк хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба, Багануур дүүрэг дэх Шийдвэр гүйцэтгэх хэсэг, Баривчлах төв, "Хэрэмт цамхаг" УТҮГ-ын эрх бүхий албан тушаалтнууд ХАСХОМ-ийн цахим бүрдүүлэлтийн талаар, ШШГБ-ын "Удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн"-д ШШГЕГ болон төв, орон нутгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, хэлтэс салбар нэгжийн дарга нарт удирдах ажилтны зүгээс авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал зэрэг 6 удаагийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>АТГ-ын "Олон нийтийн төв"-д зохион байгуулагдаж буй Нийтийн албан тушаалтнуудад зориулсан сургалтад тус байгууллагаас нэр бүхий 131 албан хаагч хамрагдсан байна. Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгжээс 2018 онд Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр албан хаагчдад 405, Сургалт хүмүүжлийн байгууллага, 413, 415, 417, 423, 425, 427, 429, 433, 437, 439, 441, 443, 445, 457-р хорих анги, Цагдан хорих 461-р хаалттай анги, БХЗХӨБАА, Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Баянхонгор,</p>

		<p>Өвөрхангай, Төв, Увс, Дорнод, Сэлэнгэ аймаг дахь ШШГГ, МСҮТ, СМДӨАЭАХХГ, Налайх, нь тус тус сургалт зохион байгуулсан байна.</p> <p>АТГ-аас 2018.12.05-ны өдөр зохион байгуулагдсан "Хууль дээдлэх ёс ба авлига, ашиг сонирхлын зөрчил" сэдэвт хэлэлцүүлэгт ХШГазрын дарга, хурандаа М.Алтан-Очир, мэргэжилтэн, дэслэгч Ч.Чимидцэрэн нар, 2018.12.12-ны өдөр Эрх бүхий албан тушаалтны сургалтад мэргэжилтэн, дэслэгч Ч.Чимидцэрэн, 2018.12.24-12.25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан сургагч багш бэлтгэх сургалтад ХШГ-ын мэргэжилтэн, дэслэгч Ч.Чимидцэрэн, СУХОГ-ын ахлах мэргэжилтэн, хошууч Б.Билэгдэмбэрэл нар тус тус хамрагдсан.</p> <p>2018 онд албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн иргэн, албан хаагчийн "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, ирсэн дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилсон.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/249 дүгээр тушаалаар "2018 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд зохион байгуулах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр"-ийг боловсруулан батлуулж, дараах сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/50 дугаар тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийгмийн ажилтны мэргэшүүлэх сургалтад 53, Сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх сургалтад 26, нийт 79; - Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийн Сувилахуйн албатай хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сувилагчдыг мэргэшүүлэх, кредит олгох сургалтад 75; - 2018 оны 05 дугаар сарын 15-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан санхүүгийн алба хаагчдын бүсчилсэн сургалтад 190; - Хорих байгууллагын хуяглан хүргэлтийн ажилтны мэргэшүүлэх сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд Хууль сахиулахын их сургууль, Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан сургалтад 35; - 2018 оны 05 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Хорих ангийн харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх сургалт"-д 23 алба хаагч, - 2018 оны 09 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Иргэний, Захирааны, Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон эрэн сурвалжлах ажиллагааны чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг нэр мөр ойлголтоор хэрэгжүүлэх нь" сэдэвт сургалтад төв, орон нутаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хэсгийн 52 ахлах шийдвэр гүйцэтгэгч; - 2018 оны 10 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд хорих анги, байгууллагын инженер, техникч, холбоочин, дүрс бичлэгийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад 78; - 2018 оны 10 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд хорих анги, байгууллагын сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад 53; - 2018 оны 10 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарыг мэргэшүүлэх сургалтад 53;
--	--	--

		<p>- 2018 оны 11 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд хорих анги, байгууллагын эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад 80;</p> <p>- 2018 оны 12 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд хорих анги, байгууллагын цагдан хорих байрны дарга, ахлах төлөөлөгч нарыг мэргэшүүлэх сургалтад 48 алба хаагч тус тус хамрагдлаа.</p> <p>Алба хаагчдыг чадавхижуулах ажлын хүрээнд ХСИС-ийн Ахлагчийн сургуультай хамтран ШШГБ-д энгийнээр томилогдон ажиллаж буй 115 шийдвэр гүйцэтгэгчид "Цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох", ШШГБ-д цэргийн орон тоонд энгийнээр томилогдон ажиллаж буй 35 алба хаагчид "Цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох", АТГ-ын Олон нийтийн төвөөс удирдах албан тушаалтан, хууль, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааг хариуцсан 131 алба хаагчид тус тус сургалт зохион байгууллаа.</p> <p>Мөн хорих анги, байгууллагуудад шинээр томилогдон ажиллаж байгаа 54 алба хаагчдад цэргийн хэргийн мэдлэг олгох давтан сургалтыг 2018 оны 09 дүгээр сарын 17-21-ний өдрүүдэд зохион байгуулж, "Гэрчилгээ" олгосон.</p>
		<p>ХОЁР ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРЭГ БОЛОН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:</p>
	<p>2.3.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас тараагдсан материал, гарын авлагыг албан хаагч, иргэдэд чөлөөтэй авах орчныг бүрдүүлэх.</p> <p>2.3.2. "Та авлигагүй бүсэд нэвтэрлээ" мэдээллийн самбарыг тогтмолжуулж, иргэдэд авлигын талаар мэдээлэл авах нөхцлийг тогтмол бүрдүүлэх.</p>	<p>ШШГЕГ-ын Хяналт шалгалтын газраас зурагт хуудас, ном, эрх бүхий албан тушаалтны 6 дахь дугаарын гарын авлагыг нийт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, хэлтэс салбар нэгжүүдэд тараасан ба салбар нэгж нь зурагт хуудсыг хөдөлгөөнт цэгүүдэд байршуулж, ШШГЕГ нь "Та Авлигагүй бүсэд нэвтэрлээ" мэдээллийг ШШГЕГ-ын электрон самбарт, салбар нэгж нь "Авлигын эсрэг хамтдаа", "Манайх Авлигагүй байгууллага" Та авлига өгөхгүй, бид авахгүй" зэрэг зурагт хуудсыг нэгжийн "Нэг цонхны үйлчилгээний төв" болон "Утга үйлчилгээ"-нд байршуулан, АТГ-ын www.iaas.mn хаягийн шинэ мэдээллийг татан авч, холбогдох мэдээллийн самбарыг тогтмол шинэчлэн ажиллаж байна. /Анги, албадууд нотлох нотломжийг зурагжуулан ирүүлсэн болно/.</p> <p>Авлигын талаар санал хүсэлт авах саналын хайрцгийг "Нэг цонхны үйлчилгээ", "Утга үйлчилгээ"-нд байршуулж, мэдээлэл авах жижүүрийн утсыг нэгж бүр ажиллуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд иргэдээс авлигатай холбоотой мэдээлэл, санал, хүсэлт ирээгүй болно.</p> <p>Мөн Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ШШГЕГ болон харьяа салбар нэгжийн нийт 51 цахим хуудаст авлигын мэдээлэл авах 1800-1969 дугаарын /баннер/ утсыг байршуулж ажилласан.</p>
3.	<p>Төрийн байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах</p>	<p>2.3.3. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, дүрэм, зааврыг алба хаагчдад хүргэх, танилцуулах.</p>
4.	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж</p>	<p>2.4.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх журмын төслүүдийг холбогдох алба, газар, нэгжээр дамжуулан алба хаагчдад</p>

	<p>мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох</p>	<p>танилцуулах, хэлэлцүүлэх, санал авч, тусгах.</p> <p>2.4.2. Нийтээр дагаж мөрдөх актын төсөлд санал авах.</p> <p>2.4.3. Шинээр боловсруулагдаж батлагдсан бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг цахим хуудсанд байршуулан олон нийтэд танилцуулах.</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018.02.06-ны өдрийн 1-4/689 дүгээр албан бичгээр ирүүлсэн "Гэр бүлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөлд алба, газар, хэлтсээс санал авч, 2018.02.15-ны өдрийн 01/536 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд хариу хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарлах тухай 32 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах журам", "Шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын журам"-ыг тус тус цахим хуудсанд байршуулсан.</p>
<p>5.</p>	<p>Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах</p>	<p>2.5.1. Хяналт шалгалтын газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг хийж, дүнг цахим хуудсанд байршуулах.</p>	<p>ШШГЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газраас 2018 онд Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь ШГХэсэг, 435-р хаалттай хорих анги, Дархан-Уул аймаг дахь ШШГГ-445 дугаар нээлттэй хорих анги, Өмнөговь, Дундговь, Төв аймаг дахь ШШГГ, Говьсүмбэр аймаг дахь ШШГГ-425 дугаар нээлттэй хорих анги, 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, 421 дүгээр нээлттэй хорих анги, Налайх дүүрэг дэх Шийдвэр гүйцэтгэх тасагт иж бүрэн төлөвлөгөөт хяналт шалгалт, Дорнод, Увс аймаг дахь ШШГГ-т гүйцэтгэлийн хяналт шалгалтыг явуулж, дүнг ШШГЕГ-ын даргын зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Хяналт шалгалтаар ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй гүйцэтгэж зөрчил, дутагдал заагдсан нэр бүхий 10 албан хаагчид ШШГЕГ-ын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан. ШШГЕГ-ын цахим хаягт тухай бүр мэдээллийг нийтэлсэн.</p>
<p>6.</p>	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p>	<p>2.6.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шийдвэр гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт авахад бүрдүүлэх материал, хаана, хэнд, хэрхэн хандах зэргийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр цахим хуудсанд тухай бүр байршуулах.</p> <p>2.6.2 Томилогдохын өмнөх сургалтад хамрагдах иргэдэд бүрдүүлэх материал, бүртгэлийн мэдээллийг ил тод нээлттэй байдлаар цахим хуудаст байршуулах.</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шийдвэр гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт авахад бүрдүүлэх материал, хаана, хэнд, хэрхэн хандах зэргийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр буюу цахим хуудсанд тухай бүр байршуулсан бөгөөд Шийдвэр гүйцэтгэлийн сул тойргийг нөхөн бүрдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчийн нөөцийн бүртгэл бий болгох зорилгоор 2018 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр сонгон шалгаруулалт товлон зарласнаас нийт 220 оролцогч бүртгүүлж, үүнээс 189 оролцогч шалгалтанд хамрагдаж, шалгалтанд 27 оролцогч тэнцэж, нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн бөгөөд 2018 оны жилийн эцэст Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст 10 оролцогч шийдвэр гүйцэтгэгчээр томилогдсон.</p> <p>ШШГЕГ-ын www.cd.gov.mn цахим сайтад "Өргөдөл, гомдол", "Хүсэлт гаргах" буланг нээн иргэдээс цахим хэлбэрээр өргөдөл, гомдол, санал хүсэлтийг авах боломжийг бүрдүүлж, Хүний нөөц, сургалт цэсэнд ажлын байрны сул орон тоо, ажилд ороход бүрдүүлэх материалыг жагсаалтыг тогтмол байршуулж хэвшсэн.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, ахлагч бүрэлдэхүүний нөөц бүрдүүлэх зорилгоор харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтыг 2018 онд 3 удаа зохион байгуулсан. 1 дүгээр ээлжийн сургалтнаас 90, 2 дугаар ээлжийн сургалтнаас 75 иргэн тус тус тэнцэж хорих анги, байгууллагад томилогдон ажиллаж байна.</p>

7.	Албан хаагч ажил бүрийн үүргийн хуваарийг тодорхой болгох	2.7.1 Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг хууль, журамд нийцүүлэх. 2.7.2 Байгууллагын бүтцийн нэгжийн ажил үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/293 дугаар тушаалын дагуу ШШГЕГ-ын даргын 2018 оны 01 дүгээр 16-ны өдрийн Б/70 дугаар тушаалаар ШШГЕГ-ын бүтэц, орон тоо, 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/52 дугаар тушаалаар ШШГЕГ-ын алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг МУ-ын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу шинээр 9, албан тушаалын нэршил өөрчлөгдсөн 62, шинэчлэн найруулсан 7 нийт 78 ажлын байрны тодорхойлолтыг тус тус баталлаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн б/70 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан бүтэц орон тооны схем, алба, газруудын үйл ажиллагааны чиглэл, үүргийн мэдээллийг цахим хуудсанд шинэчлэн байршуулсан.
8.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	2.8.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-уудыг шинэчлэн томируулж, ажлын байрны тодорхойлолтыг батлуулах. 2.8.2 Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгжийн шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-уудад сургалт зохион байгуулах, үүрэг, чиглэлээр хангах.	2018 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжид 14 эрх бүхий албан тушаалтан томилогдсон бөгөөд эрх бүхий албан тушаалтнаас нууцын баталгааг гаргуулан авч, эрх бүхий албан тушаалтны эрх цахимд үүсгэж өгч, гарын авлага, үүрэг чиглэл, мэдээллээр тухай бүр ханган ажилласан. 2018 онд 401,403, 405, 407, 409, 411, 415, 421, 429, 441-р Хорих анги, Цагдан хорих 461-р анги, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Банк хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба, Багануур дүүрэг дэх Шийдвэр гүйцэтгэх хэсэг, Баривчлах төв, "Хэрэмт цамхаг" УТҮГ-ын эрх бүхий албан тушаалтнуудыг 2 удаагийн сургалтад хамруулж тухай бүр үүрэг, чиглэл, заавар зөвлөмжөөр ханган ажилласан. 2019 оны 01 дүгээр сард Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги салбар нэгжүүдийн дотоод хяналт шалгалт, хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан эрх бүхий албан тушаалтныг шинэчлэн томилуулах, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулахаар ШШГЕГ-ын 2018-2019 онд явуулах сургалтын төлөвлөгөөнд тусгуулсан.
9.	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах/	2.9.1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, санал, хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, бүртгэн мэдээллийн санд оруулж, шийдвэрлэлтийг цахим хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах, шийдвэрлэлтэд удирдлагын зүгээс байнга хянаж, хүний зөрчигдсэн эрх, эрх чөлөөг хангаж ажиллах. 2.9.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад биеэр хандаж ирсэн иргэнийг угтах "Нэг цонхны	ШШГЕГ-ын www.sd.gov.mn цахим сайтад "Өргөдөл, гомдол", "Хүсэлт гаргах" гэсэн цэс нээж иргэдээс цахим хэлбэрээр өргөдөл, гомдол, санал хүсэлтийг авах боломжийг бүрдүүлсэн. Тайлант хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой 73 өргөдөл, гомдол цахим хэлбэрээр ирүүлснийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг өгсөн. Мөн байгууллагын фэйсбүүк хуудасны онлайн чатаар хандсан 158 иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, сургалтын чиглэлээр асуусан асуултад хариу мэдээллийг цаг тухай бүрт нь өгч ажилласан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Нэг цонхны үйлчилгээ"-ний төвд нийт 791 иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авч, хууль журмын дагуу шийдвэрлэн, хариуг хүргүүлж ажиллалаа. Хүлээн авсан 791 өргөдөл, гомдлыг газар хэлтсээр нь авч үзвэл, Захиргааны

	<p>үйлчилгээ"-г боловсронгуй болгох, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, байгууллагын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, иргэд, олон нийтийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх.</p>	<p>удирдлагын газарт 179, Шийдвэр гүйцэтгэх албанд 301, Хорих ял эдлүүлэх албанд 246, Хяналт шалгалтын газарт 62, Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газарт 3 өргөдөл тус тус ирүүлсэн байна.</p> <p>Нийт 397 иргэнээс "Сэтгэл ханамжийн үнэлгээний хуудас"-аар судалгаа авахад 146 буюу 36.7 хувь нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түргэн, шуурхай нээлттэй байлгах тухай, 89 буюу 22.4 хувь нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй хүргэж байх, үлдсэн 162 буюу 40.9 хувь нь ямар нэгэн санал гаргаагүй болно.</p>
2.9.3.	<p>Албан хаагчийн хууль бус үйлдэл, авлига, хүнд суртлын талаар бичгээр ирсэн гомдолд шалгалт хийж, шийдвэрлэж байх.</p>	<p>2018 онд Хяналт шалгалтын газраас албан хаагчийн хууль бус үйлдэл, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой 3 /403, 433, БХХТБАА/ асуудалд албаны шалгалт явуулж, холбогдох албан тушаалтан нарт ШШГЕГ-ын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан.</p>
2.9.4.	<p>Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар мэдээлэх.</p>	<p>ШШГЕГ-т иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар бүр байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулж хэвшсэн.</p> <p>Улирал бүрийн өргөдөл, гомдлын мэдээг www.cd.gov.mn сайтад байршуулж, 1 дүгээр улирлын мэдээг 2018.03.26-ны өдрийн 01/1083, дээд газраас шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2018.04.02-ны өдрийн 01/1146, эхний хагас жилийн өргөдөл, гомдлын мэдээг 2018.06.22-ны 01/2523, дээд газраас шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2018.06.22-ны өдрийн 01/2524, 3 дугаар улирлын өргөдөл гомдлын мэдээг 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01/3812, жилийн эцсийн өргөдөл гомдлын мэдээг 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/4974 дүгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p>
2.9.5	<p>Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, харилцах утас, иргэнийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулах, дүнг олон нийтэд цахим хуудсаар мэдээлэх.</p>	<p>ШШГЕГ-ын дарга "Иргэд хүлээн авах хуваарь"-ийн дагуу 2018 онд орон сууц хүссэн 9, орон сууц хувьчилж өгөхийг хүссэн 2, шилжүүлэн томилж өгөхийг хүссэн 10, албан тушаал дэвшүүлэн томилж өгөхийг хүссэн 1, хорих анги шилжүүлэхийг хүссэн 4, тушаалд өөрчлөлт оруулах тухай 3, ажилд орохыг хүссэн 16, эд материалын тусламж хүссэн 4, офицерийн бүрэлдэхүүнд орохыг хүссэн 3, чөлөө олгож өгөхийг хүссэн 1, хоригдлоос төлбөр барагдуулах тухай 1, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлж өгөхийг хүссэн 21, урьд ажиллаж байсан цалингийн тодорхойлолт авах тухай 1, цагдаагийн байгууллагад шилжүүлэх тухай албан бичиг хүссэн 1, хоригдолд чөлөө олгохыг хүссэн 1, нийт 78 иргэнийг тус тус хүлээн авч уулзаж, хүсэлтийг нь хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллалаа.</p>
10.	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p>	<p>2018 онд Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр албан хаагчдад 405, Сургалт хүмүүжлийн байгууллага, 413, 415, 417, 423, 425, 427, 429, 433, 437, 439, 441, 443, 445, 457-р хорих анги, Цагдан хорих 461-р хаалттай анги, БХХХӨБАА, Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Увс, Дорнод, Сэлэнгэ аймаг дахь ШШГТ, МСҮТ, СМДӨАЭАХХГ, Налайх, Багануур дүүрэг дэх ШГТ нь тус тус сургалт зохион байгуулсан байна.</p>

11.	<p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах</p>	<p>2.11.1. Албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн, хуулийн хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.</p>	<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу мэдүүлэг гаргавал зохих нийт албан тушаалтнаас хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авсан.</p>
12.	<p>Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах</p>	<p>2.12.1 Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлтэй хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг байгуулан, хамтран ажиллах</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, бригадын генерал Ц.Амгаланбаяр, Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн дарга Г.Баасан нар авлигын эсрэг хамтран ажиллах санамж бичиг 2018 оны 06 дугаар сарын 05-ны гарын үсэг зурсан. Хамтын ажиллагааны хүрээнд талууд эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтран хэлэлцүүлэг, зөвлөгөөн, нийтийн сонголыг зохион байгуулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын дунд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд мэтгэлцээн, онол практикийн бага хурал, сургалт зохион байгуулах, авлигатай тэмцэх чиглэлээр явуулж буй бодлого, үйл ажиллагааг олон нийтэд тайлбарлан таниулах, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд шуурхай хүргэх боломжийг улам бүр нэмэгдүүлэх чиглэлээр харилцан хамтран ажиллах юм. Тус арга хэмжээний талаарх мэдээг "Өглөөний сонин"-ы №106 дугаар, news.mn, mnb.mn, bataaг.mn сайтад тус тус нийтлүүлсэн.</p> <p>АТТ-ын Олон нийтийн зөвлөлийн дарга Г.Баасан болон бусад гишүүдийн хамт ШШГЕГ-ын харьяа 407, 409, 429 дүгээр нээлттэй хаалттай хорих ангиудын үйл ажиллагаатай танилцуулсан. Уг санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан, ШШГЕГ-ын алба, газар хэлтэс, хорих анги, байгууллагад 2018.09.17-ны өдрийн 06/3591 дүгээр албан бичгээр хүргүүлэн, биелэлтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэв.</p> <p>ШШГЕГ-ын "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө", "Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 төлөвлөгөө"-ний биелэлтийг 2018 оны 1, 3 дугаар улирлын байдлаар нэгтгэн, дүнг ШШГЕГ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.</p> <p>"Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж"-ийн биелэлтийг 2018 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн 2018.06.20-ны 01/2483, жилийн эцсийн байдлаар нэгтгэн 2018.11.30-ны өдрийн 01/4666 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд тус тус хүргүүлсэн.</p> <p>Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсанаар байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд ШШГЕГ-ын алба, газар, хэлтэс нь www.cd.gov.mn, харьяа хорих анги, байгууллагууд нь өөрийн цахим сайтад авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 удаагийн цаг үеийн мэдээллийг нийтэлсэн.</p> <p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ШШГБ-ын хэмжээнд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах нэр бүхий албан хаагчдаас мэдүүлгийг хуулийн хугацаанд 100 хувийн бүрдүүлэлттэй гаргуулан авч, ШШГЕГ-ын Авлигаас урьдчилан сэргийлэх үйл</p>

			<p>ажиллагааны 2017 оны төлөвлөгөөний биелэлт, бусад тайлан, мэдээний хамт Авлигатай тэмцэх газарт 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>АТГ-тай хамтран Говьсүмбэр аймаг дахь ШШГГ-425 дугаар нээлттэй хорих анги, Орхон аймаг дахь ШШГГ-437 дугаар нээлттэй хорих анги, Дорноговь, Булган аймаг дахь ШШГГ-ын эрх бүхий албан тушаалтан, мэдүүлэг гаргагч нарт, 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр 401, 403, 405, 407, 409, 411, 415, 421, 429, 441 дүгээр нээлттэй, хаалттай хорих анги, Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Банк хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба, Баривчлах төв, "Хэрэмт цамхаг" УТҮГ-ын эрх бүхий албан тушаалтнуудад "ХАСХОМ-ийн цахим бүрдүүлэлтийн талаар", ШШГБ-ын болон төв, орон удирдах ажилтнуудад "Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал" зэрэг 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Улсын их хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвөөс зохион байгуулж байгаа нийтийн албан тушаалтан, худалдан авах ажиллагаа, санхүү, төсөв хариуцсан ажилтнуудад зориулсан сургалтад нийт 131, Авлигатай тэмцэх газраас 2018 оны 04 сарын 17-ны өдөр нийтийн албан тушаалд анх удаа томилогдсон ажилтны сургалтад 10 албан хаагчийг тус тус хамрууллаа.</p> <p>ШШГГГ-ын даргын баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу 7 хоног бүрийн "Даваа гараг"-т мэдээллийн цаг хөтөлбөрийг зохион байгуулж, албан хаагчдыг бүрэн хамруулсан.</p>
13.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	<p>2.12.2. Төрийн бус байгууллагатай хамтран алба хаагчдад сургалт зохион байгуулах.</p> <p>2.12.3 Хоригдлыг нийгэмшүүлэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, хүмүүжлийн ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байх.</p>	<p>Хорих ял эдлүүлэх албаны Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс нь хоригдлыг нийгэмшүүлэх, суллагдсаны дараа нийгэмд ороход нь туслалцаа дэмжлэг үзүүлэх, зорилгоор 2018 онд 17 төрийн бус байгууллага, 2 төрийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан хоригдлуудад сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан.</p>
	2.13.1 ШШГБ-ын албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагчийн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалган тогтоох.		<p>ШШГГГ-ын даргын 2017.03.10-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар баталсан "ШШГБ-ын ажилтны ёс зүйн дүрэм"-ийн биелэлтийг харьяа хорих анги, байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэхэд Монгол улсын хууль тогтоомж, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийг биелүүлж, эрхээ хэрэгжүүлэх явцад баримтлах хуульд нийцүүлэн гаргасан заавар, журам, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэд, байгууллага, алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл болон хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг шалган дүнг "Ёс зүйн салбар хороо"-ны хуралдаанаар хэлэлцэн, зөрчил гаргасан эсэх, тухайн ажилтан гэм буруутай эсэх, түүнд хариуцлага хүлээлгэх эсэх талаар гишүүдийн олонхийн саналаар дүгнэлт гаргаж, тухайн нэгжийн даргын зөвлөлийн хуралдаанд санал уламжлан шийдвэрлэж хэвшсэн байна.</p> <p>"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм"-ийг алба хаагчдад чанд мөрдүүлэх, сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр хичээл сургалтыг зохион байгуулан, албан үүргээ гүйцэтгэхдээ албаны нэр төрийг өндөрт өргөж, аливаа зөрчил гаргахгүй ажиллахыг үүрэг</p>

<p>болгосны зэрэгцээ дотооддоо "Ёс зүйн талон", "Сахилгын хуудас", "Сахилгын талон" зэргийг санаачлан хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p>Анги, байгууллагуудаас ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарч ажиллах үүргийг ШШГЕГ-ын даргын 2018.07.06-ны өдрийн 01/2745 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд алба хаагчийн ёс зүйн асуудлаар нийт 14 гомдол хүлээн авч, албаны шалгалт явуулж, ёс зүйн зөрчил, алдаа дутагдал гаргасан нь тогтоогдсон 6 гомдлын дагуу ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлэн 6 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.</p> <p>Засгийн газраас 2018 оныг "Хариуцлагын жил" болгосонтой холбогдуулан ШШГЕГ-ын даргын "Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх тухай" 2018.02.08-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд харьяа орон нутгийн болон хотын бүсийн хэмжээнд "Сахилга, хариуцлагын зөвлөгөөн"-ийг 2 удаа тус тус зохион байгуулж, ШШГЕГ-ын удирдлагууд тус байгууллагын бүх шатны удирдах ажилтан, нийт бие бүрэлдэхүүнд хандаж сахилга, хариуцлага, дэг журам, гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сайжруулах чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгсөн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.09.27-ны өдрийн А/183 дугаар тушаалаар "ШШГБ-ын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм" батлагдаж, хорих анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p>	
<p>МУ-ын Засгийн газраас 2018 оныг "Хариуцлагын жил" болгосонтой холбогдуулан ШШГЕГ-ын даргын "Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх тухай" 2018.02.08-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаас тус байгууллагын удирдах ажилтнуудад өгсөн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ШШГЕГ-ын даргын 2018.04.03-ны өдрийн А/78 дугаар тушаалын дагуу ШШГЕГ-ын харьяа орон нутаг дахь хорих анги, байгууллагуудад "Сахилга, хариуцлагын зөвлөгөөн"-ийг 2018 оны 04 дүгээр сарын 09-13-ны өдрүүдэд, ШШГЕГ-ын алба, газар, нийслэлийн хүрээний хорих анги, байгууллагуудын ахлах мэргэжилтнүүд болон түүнээс дээш албан тушаалд ажиллаж буй 173 удирдах ажилтнуудыг оролцуулсан "Сахилга хариуцлагын нэгдсэн зөвлөгөөн"-ийг 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр тус тус зохион байгуулан нийт бие бүрэлдэхүүнд сахилга, хариуцлага, дэг журам, гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгсөн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд алба, газар, хорих анги, байгууллага бүр "Ажлын хэсэг" байгуулан албаны байр, өрөө тасалгаанд согтууруулах ундаа хэрэглэх, хадгалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг дээшлүүлэх, сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах зорилгоор алба хаагчдын ажлын байрны сахилга бат, зохион байгуулалт, баримт бичгийн эмх цэгц, хадгалалт хамгаалалт, хорiotой эд зүйл байгаа эсэхийг нэг бүрчлэн шалгалаа.</p> <p>Үзлэгээр ямар нэгэн согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис гараагүй бөгөөд цаашид бичиг баримтын хадгалалт, хамгаалалт, эмх цэгцийг хангаж, ажлын байрны ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, албан ерөөндөө, үүрэг гүйцэтгэх үедээ, үүрэг гүйцэтгэхээр ирэхдээ архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх талаар үүрэг өгч, алба хаагчаар гарын үсэг зуруулан баталгаажууллаа.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/148 дугаар тушаалаар ШШГЕГ-ын даргын 2013 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан</p>	<p>2.13.2. Алба хаагчдын ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулах,</p>

			<p>“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 5.4-д “алба хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглоно” гэж нэмэлт өөрчлөлт оруулав.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, харьяа нэгжийн удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаалыг 2018 онд батлагдсан/ цахим хуудсанд тухай бүр байршуулан ажилласан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • ХЗДХСайдын 2018.07.30-ны өдрийн А/150 дугаар тушаалаар батлагдсан “Хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх журам”, • ХЗДХС болон Сангийн сайдын 2018.04.06-ны өдрийн А/63, А/70 дугаар тушаалаар батлагдсан “Баривчлагдсан этгээдийн баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээ”, • ХЗДХС, СС-ын 2018.06.06-ны өдрийн А/107, 137 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох, зарцуулах, төлбөр авагчид буцаан олгох журам”, • ХЗДХС-ын 2018.05.08-ны өдрийн А/86 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн тойрог тогтоох тухай” • ХЗДХС, ЗГХЭГ-ын даргын 2018.11.23-ны өдрийн А/217, 272 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “ШШГБ-д үүрэн холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж суурилуулах, ашиглах журам”, • ХЗДХС, УЕП-ын 2018.06.29-ний өдрийн А/127, А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дэглэм”, • ХЗДХС, ЗМС-ын 2018.11.19-ний өдрийн А/214, А/462 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүнд өвчтэй хоригдлыг хорих ангиас гадуур эмнэлэгт шилжүүлэн эмчлүүлэх журам”, • ХЗДХС-ын 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар батлагдсан “ШШГБ-ын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах журам”, • ХЗДХС-ын 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/183 дугаар тушаалаар батлагдсан “ШШГБ-ын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм” зэрэг болно.
14.	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах	<p>2.14.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, харьяа нэгжийн удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаалыг цахим хуудсанд тухай бүр байршуулах.</p> <p>2.14.2 Байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах.</p> <p>2.14.3 Үйлчлүүлэгчээ авч буй төлбөрт үйлчилгээ, төлбөр болон хураамжийг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах.</p>	<p>ШШГЕГ-ын www.cd.gov.mn цахим сайтанд байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй Монгол Улсын хууль 7, Засгийн газрын тогтоол 6, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал 18, Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоол 1, ШШГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан 28 нийт 60 эрх зүйн актуудыг тухай бүр шинэчлэн байршуулсан.</p> <p>ШШГЕГ-ын www.cd.gov.mn цахим сайтны “Төрийн үйлчилгээ үзүүлэх” цэсэнд Өр төлбөртэй эсэх лавлагаа, Суллагдлын лавлагаа, Архивын лавлагааг хэрхэн авах талаарх мэдээллийг оруулсан.</p>
15.	Төрийн байгууллага хоорондын хамтын	2.15.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран	Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Хууль сахиулах их сургуулиас хэрэгжүүлж буй “Дэлхийн зарим улс орнуудын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны зүй тогтол, арга зүй, эрх зүйн зохицуулалт, чиг хандлагын харьцуулсан судалгаа” шинжлэх ухаан, технологийн төслийн хүрээнд зохион байгуулж буй “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх

	<p>ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах</p>	<p>ажиллах, байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг сурталчлах.</p>	<p>ажиллагаа, хэрэгжилт, чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр тус албаны алба хаагчид илтгэл тавьж, хэлэлцүүлсэн.</p> <p>Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний талаар судалгаа боловсруулалтын ажил гүйцэтгэх, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр албаны дарга, хурандаа Х.Ариунболд, Албадлагын арга хэмжээ, хяналтын хэлтсийн дарга, хошууч Р.Саруултамир, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа М.Эрдэнэбаяр, тус хүрээлэнгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хурандаа Б.Алтангэрэл нар 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албыг төлөөлж Албадлагын арга хэмжээ, хяналтын хэлтсийн дарга, хошууч Р.Саруултамир, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийг төлөөлж Бодлогын хэрэгжилт, нийгмийн оролцооны хэлтсийн дарга С.Батбаяр нар нь “Сургалт явуулах чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг”-ийг 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2 жилийн хугацаатай байгуулсан. “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд тус төвийн нийгмийн оролцоо хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Хурццэг, сэргээн засалт, судлалын асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Уянга, сэтгэл зүйч Г.Энхбаяр нар “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Хорт зуршлаас татгалзах”, “Архи болон мансууруулах бодисын хор хөнөөл, түүнээс үүдэн гарах үр дагавар” зэрэг сэдвүүдийн хүрээнд 2 цагийн сургалтыг Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын алба хаагч болон эмчлүүлж буй этгээдүүдэд зохион байгуулсан.</p> <p>Мэргэжилтэн, ахлах дэслэгч У.Энэрэл Согтуурах, мансуурах донтой өвчтөн албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчлүүлэгсдэд хамтран сургалт зохион байгуулах, эмнэлгээс гарсны дараа ажил, хөдөлмөрөөр хангах боломж нөхцлийн талаар “Монголын чөлөөт нийгмийн ажилтны төв”-ийн тэргүүн Г.Баярмаатай уулзаж, харилцан мэдээлэл солилцсон. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Өөртөө туслах бүлэг”-ийн гишүүд Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт “Зөв зохист хандлагыг түгээн дэлгэрүүлэх хамтын ажиллагаа” сэдэвт сургалт зохион байгууллаа.</p> <p>ХӨТЯЭАлбаны дарга, хурандаа Х.Ариунболд 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл, мэргэжилтэн Н.Хишигтогтох нарт Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар, Баривчлах төвийн өдөр тутмын үйл ажиллагааг танилцуулан, албан хаагч болон өвчтэй этгээд тус бүртэй уулзалт зохион байгуулсан.</p> <p>“Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллагаас 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 03/04 тоот албан бичгээр ирүүлсэн хамтран ажиллах, сургалт зохион байгуулах хүсэлтийн дагуу Албадлагын арга хэмжээ, хяналтын хэлтсийн дарга, хошууч Р.Саруултамир, мэргэжилтэн, ахлах дэслэгч Л.Чойндонжамц, мэргэжилтэн, ахлах дэслэгч У.Энэрэл, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллагын тэргүүн Г.Загдаа нар 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчлүүлж буй 123 өвчтөнд “Мансуурлын шалтгаан нөхцөл”, “Мансуурах, донтох ойлголтын тухай”, “Мансуурах, донтохоос хэрхэн ангирах вэ” гэсэн сэдвийн хүрээнд өвчтнүүдийг нийт 6 багт хуваарилан нүүр тулсан ярилцлага, хэлэлцүүлэг хэлбэрээр сургалтыг зохион байгуулан ажилласан.</p> <p>“Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2018 оны 04</p>
--	---	--	--

	<p>дүгээр сарын 26-ны өдөр "Гэр бүл хүүхдийн сэтгэл зүйн боловсролыг дэмжих төв"-ийн сэтгэл зүйч Н.Амаржаргалтай уулзалт хийж, аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хяналтад байгаа зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан нийт 30 этгээдэд "Харилцаа ба хандлага";</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хэсгүүдийн зан үйлээ засах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр "Амар судлалын төв"-тэй хамтран "Хандлага", "Өөрийгөө хэрхэн ялан дийлэх";</p> <p>Зан үйлээ засах албадлагын арга хэмжээ авагдсан 28 этгээдэд Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн харуул хамгаалалтын тэнхимийн багш, сэтгэл зүйч, ахлах дэслэгч Б.Мөнхбаатар 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдөр "Хувь хүний хөгжил", "Дотоод ба гадаад ертөнцийн ялгаа";</p> <p>Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан 90 этгээдэд "Эрчүүд гэр бүл" төрийн бус байгууллагын тэргүүн О.Эрдэнэцогт 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдөр "Хувь хүн өөрийгөө танин мэдэх", "Хувь хүний телевизил", "Харилцан ойлголцол" сэдвүүдээр цахим сургалт;</p> <p>Орон нутаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хэсгийн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нарт Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуультай хамтран 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр "Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдтэй харилцах", "Ялын бодлого", "Зан үйлээ засах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд сургалт зохион байгуулахад анхаарах зүйлс" сэдвүүдээр цахим сургалт;</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/192 дугаар тушаалыг үндэслэн аймаг, нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хэсгийн "Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нарыг мэргэшүүлэх 14 буюу 2.3 кредит цагийн сургалт"-ыг 2018 оны 11 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд Хууль сахиулахын их сургуультай хамтран "Эрдэм" танхимд тус тус зохион байгуулсан.</p> <p>Хорихоос өөр төрлийн ялын бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, ахмад Д.Чимгээ Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн I дүгээр сувгаар "Иргэдийн эрх зүйн боловсролд" нэвтрүүлэгт 2018 оны 07 дугаар сарын 18-ны өдөр оролцож хорихоос өөр төрлийн ял, түүний хэрэгжилт орон нутагт хэрхэн хангагдаж байгаа талаар мэдээлэл өгсөн.</p> <p>Мөн Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн дарга, ахлах дэслэгч Э.Итгэлтөгс 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр тус нэвтрүүлэгт оролцож тэнсэж, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, хорихоос өөр төрлийн ялын талаар иргэдэд нээлттэй утсаар мэдээлэл өгч ажилласан.</p> <p>2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Парламент телевизээр олон нийтэд хүрсэн "Би асууя" нэвтрүүлэгт Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Х.Ариунболд, Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын сэтгэл зүйч, ахмад Б.Нармандах нар оролцож тус газрын үйл ажиллагааны талаар танилцуулан, мэдээлэл өгсөн.</p> <p>Албадлагын арга хэмжээ, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Ц.Ганчимэг Монголын Үндэсний радиогийн Хурд агентлагаас бэлтгэдэг хууль зүйн мэдээллийн "Соёмбо" хөтөлбөрт 2018 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр оролцож, Эрүүгийн хууль болон Шүүхийн</p>
--	--

			<p>шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан тэнсэн, албадлагын арга хэмжээний зохицуулалтын талаар болон албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийн өнөөгийн хэрэгжилтийн талаар арилцлага өгсөн.</p> <p>Согуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт 2018 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан "Эдгэрлийн аян" арга хэмжээнд ахлах мэргэжилтэн, хошууч Ц.Ганчимэг, мэргэжилтэн, ахлах дэслэгч О.Буянжаргал нар оролцсон ба тус арга хэмжээний талаар Парламент телевизээр сурталчилсан.</p>
		<p>2.15.2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд төрийн байгууллага болон Арилжааны банкуудтай мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллах.</p>	<p>Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай гүйцэтгэх, ажлын ачааллыг багасгах, зардлыг бууруулах зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Зам тээврийн яам, Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Капитал банк, Капитал банктай өмнөх онуудад хэрэгжүүлж байсан хамтын ажиллагааг үргэлжлүүлж, 2018 онд Улаанбаатар, Голомт банктай хамтран ажиллах гэрээ байгуулж, мэдээлэл солилцох ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлсэн,</p> <p>Шинээр батлагдсан хуулийн зохицуулалтад нийцүүлж, Худалдаа хөгжлийн банктай 2018 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн tdbm/129/2018 дугаар гэрээг шинэчлэн байгуулсан.</p> <p>Үндэсний хөрөнгө оруулалтын банктай байгуулсан харилцан мэдээлэл солилцох, гэрээний хугацааг 2020 оны 8 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл сунгаж, гэрээнд өөрчлөлт оруулсан. Мен Богд, Хаан, Кредит банктай хамтран ажиллахаар гэрээ болон өгөгдлийн нөхцлийг боловсруулах ажлыг явуулж байна. Кредит банкны мэдээллийн технологийн газрын захирал болон хуулийн мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, програм хангамжийг нөхцлийг танилцуулж, гэрээний төслийг хүргүүлсэн.</p> <p>Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаарх мэдээллийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн сангаас шийдвэр гүйцэтгэгч цахим хэлбэрээр мэдээлэл татан авах эрхийн хүрээнд 2018 онд иргэний нас баралт, гадаад паспортын дугаар, гэрлэлтийн бүртгэлийн талаарх мэдээллийг шинээр цахим санд оруулсан.</p> <p>Гаалийн байгууллагын нэгдсэн цахим санд нэвтрэх эрх олгуулахаар Гаалийн ерөнхий газарт 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 4/1649 албан бичгээр хүсэлт гаргаж, нэвтрэх 1 эрхийг олгуулан, харьяа нэгжүүдэд бараа, ачаа тээврийн экспорт, импортын талаарх 124 мэдээллийг цахим хэлбэрээр олгосон.</p> <p>Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч хилээр нэвтэрсэн эсэх талаарх лавлагаа, мэдээлэл солилцох ажлыг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор Хил хамгаалах ерөнхий газарт санал хүргүүлж, улмаар тус газрын Нууцын алба, Мэдээлэл технологийн газар, Лавлагаа, мэдээллийн тасгийн эрх бүхий албан тушаалтантай 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдөр уулзалт зохион байгуулж, Улсын ерөнхий прокурорын газар болон Тагнуулын ерөнхий газраас зохих зөвшөөрлийг авч, мэдээллийг цахим хэлбэрээр харилцан солилцохоор шийдвэрлэсний дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авахаар зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p>
16.	Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог	2.16.1. "Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын систем"-ийн шинэчилсэн програм хангамжаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад мэдээлэл өгөх, үйл	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/07 дугаар тушаалаар "Гүйцэтгэх баримт бичгийн цахим сан"-г шинэчилсэн программ хангамжид шилжүүлж үйл ажиллагаанд "Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын систем"-ийн нэвтрүүлэн, цахим хэлбэрээр мэдээлэл боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.</p>

		<p>бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх</p>	<p>ажиллагааг ил тод нээлттэй явуулах.</p>	<p>Цахим хэлбэрээр төлбөр төлөгчийн харилцах данс битүүмжлэх, суутгал хийх ажлын чиглэлээр ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарт онлайн сургалтыг зохион байгуулж, аргачлалаар хангах арга хэмжээг авсан.</p> <p>Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нээлттэй, ил тод болгох зорилгоор гүйцэтгэх баримт бичгийн цахим сангаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад онлайн хэлбэрээр мэдээлэл хүргүүлэхээр програм хангамжийн хөгжүүлэлтийг хийж, туршилтын бүртгэлийг эхлүүлсэн.</p> <p>Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудыг мэдээллээр хангах цахим хуудсыг боловсруулж, шийдвэр гүйцэтгэлийн системийн өгөгдлийн баазыг холбосон.</p>
<p>2.16.2.</p>		<p>Шийдвэр гүйцэтгэх хариуцагч, нэхэмжлэгч талуудад ажиллагааны явцын талаарх мэдээллийг цахимаар өгөх программыг боловсруулж, нэвтрүүлэх.</p>	<p>Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудыг мэдээллээр хангах цахим хуудсыг боловсруулж, шийдвэр гүйцэтгэлийн системийн өгөгдлийн баазыг холбосон.</p>	
<p>2.16.3.</p>		<p>Шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх лавлагааг иргэнд цахим хэлбэрээр олгох үйл ажиллагааг нэвтрүүлэх.</p>	<p>Шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх лавлагааг "Төрийн үйлчилгээний цахим машин"-аар иргэнд олгох саналыг ШШГЕГ-ын даргын 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, санал шийдвэрлэсэн. Уг ажлын хүрээнд Үндэсний Дата төвтэй 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж, мэдээллийн өгөгдлийг боловсруулан, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.</p>	
<p>2.16.4.</p>		<p>Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх, иргэд олон нийтийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх, бодит үнэн зөв мэдээллээр хангах.</p>	<p>Байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь www.nsc.cd.gov.mn цахим хуудсанд 2018 онд хууль эрх зүйтэй холбоотой 90, алба хаагч, байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 114, бусад 96, нийт 300 мэдээ, мэдээллийг тухай бүр оруулан ажилласан. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны сайтад тайлант хугацаанд 8792 хүн зочилж зохих мэдээ мэдээллийг авсан байна.</p>	
<p>17.</p>		<p>Төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, Албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас иргэдэд хүргэдэг үйлчилгээний талаар хөндлөнгийн буюу "Хэрэглэгчийн үнэлгээ"-г хийлгэх ажлыг "Ажиглалт" ХХК-тай гэрээ байгуулан 2018.11.14-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрүүдэд ШШГБ-ын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийлгэж, 94,3 хувь буюу 4.7 оноотой дүгнэгдсэн.</p>	
<p>18.</p>		<p>3.18.1 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах</p>	<p>ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ХҮРЭЭНД: Тайлант хугацаанд ШШГЕГ-ын www.cd.gov.mn цахим сайтад 143, фэйсбүүк хуудаст 128, дотоод мэдээллийн болон электрон самбарт 120 мэдээ мэдээллийг тус тус боловсруулан байршуулсан. Мөн байгууллагын фэйсбүүк хуудасны онлайн чатаар хандсан 158 иргэний</p>	

	<p>эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах</p>		<p>чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудсанд хариуцан оруулах мэдээллийн бүтэц, товыг боловсруулж мөрдүүлэх.</p>	<p>шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, сургалтын чиглэлээр асуусан асуултад хариу мэдээллийг цаг тухай бүрт нь өгч ажиллалаа.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд МҮОНТ-ийн олон нийтийн цаг ярилцлагын нэвтрүүлэгт 1 удаа, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, 409 дүгээр хаалттай хорих анги, Баянхонгор, Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, 435 дугаар хаалттай хорих анги, Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангиас бэлтгэсэн хоригдлын хөдөлмөр эрхлэлт, мэргэжил эзэмшүүлэлтийн талаарх бэлтгэсэн "Эрх зүйн хөтөч" нэвтрүүлэг МҮОНТ-ээр 5 удаа, МҮОНТ-ийн "Бүх нийтийн эрх зүйн боловсрол"-д нэвтрүүлэгт албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа, иргэний хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийсэн этгээдэд хүлээлтэй хариуцлага, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, "Тэжээн тэтгэх үүрэг бүхий шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа"-ны чиглэлээр 5 удаа, "Парламент" суваг телевизтэй хамтран <u>СМДӨГЭХХГ</u>-аас бэлтгэсэн "Би асууя" архинд донтолын асуудал хөндсөн нэвтрүүлэг 1 удаа, "Монгол генерал" ярилцлагын нэвтрүүлэгт 1 удаа, Хошууч генерал Ж.Содномын "Би" хөрөг нэвтрүүлэг 25 дугаар суваг телевизээр 1 удаа, МҮОНР-ийн "Соёмбо" асуулт хариултын нэвтрүүлэгт 3 удаа, телевиз, радиогийн нэвтрүүлэгт нийт 13 удаа, МҮОНТ, TV5, TV8, TV9, 25 дугаар суваг, Парламент суваг, Royal HD, NTV телевизүүдэд 28 удаа, "Зууны мэдээ" сонины 04 дүгээр сарын 13-ны өдөр бригадын генерал М.Ганхүүгийн ярилцлага 1 удаа, "Өдрийн сонин", "Өнөөдөр", "Зууны мэдээ", "Өглөөний сонин", "Үндэсний шуудан", "Монголын мэдээ", "Монголын үнэн" сонинд 45 удаа, zaluu.com, news.mn, zindaa.mn, medee.mn, dorgio.mn, montsame.mn, shuud.mn, gogo.mn, toimnews.mn, timenews.mn, bataar.mn, medee.mn, news.gogo, newspress.mn, erennews.mn, itoim.mn, arslan.mn, news.zindaa.mn, prokuror.mn, uptown.mn, sonin.mn, ulsturch.mn, mnб.mn, tsag.mn, unen.mn, jirgee.mn, shuurhai.mn, tur.mn, niisleitimes.mn сайтуудад нийт 82 удаа тус тус мэдээ мэдээлэл өгч нийтлүүлсэн.</p>
<p>19.</p>	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p>		<p>3.19.1 Сул орон тооны зарыг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах.</p> <p>3.19.2 Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох хуулийн хэрэгжилтийг хангах.</p> <p>Ажлын байрны сул орон тооны зарыг 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн "Зууны мэдээ" сонины №37, "Өнөөдөр" сонины №32 дугаар, 03 дугаар сарын 22-ны өдрийн "Өдрийн сонин", "Өнөөдөр" сонинуудад тус тус нийтлүүлсэн. Мөн байгууллагын ажлын байрны сул орон тооны зарыг 08 дугаар сарын 20-ны өдөр www.cd.gov.mn сайт, фэйсбүүк хуудаст тус тус байршуулав.</p> <p>Албан тушаалд томилогдох иргэн, алба хаагчийн "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, ирсэн дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилсон.</p>	
<p>ДӨРӨВ. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД:</p>				

<p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх</p>	<p>4.20.1. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.</p> <p>4.20.2 Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах.</p>	<p>2018 онд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтад мэдээлсэн. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нээлттэй тендер зарласан тухай бүр өдөр тутмын "Өнөөдөр" сонин болон байгууллагын цахим сайт, пэйж хуудас, байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр байршуулан ажилласан.</p> <p>Өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланг Шилэн дансны тухай хуульд тусгагдсаны дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 4-р сарын 25-ны дотор, хагас жилийн тайланг 8-р сарын 15-ны дотор, төсвийн гүйцэтгэлийн мэдээг жил бүрийн 8-р сарын 15-ны дотор, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийг дараа оны 4-р сарын 25-ны дотор, сар улирлын мэдээг дараа сарын 8-ны дотор байгууллагын болон шилэн дансны www.cd.gov.mn, www.shilendans.gov.mn сайтад тус тус байршуулсан.</p>
<p>20.</p>	<p>4.20.3 Дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд байршуулах.</p> <p>4.20.4 Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулах.</p> <p>4.20.5. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар ШШГЕГ-ын даргын зөвлөлд мэдээлэл хийх, салбар зөвлөлд ирүүлэх. Цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.</p>	<p>2018 оны батлагдсан төсвийн мэдээллийг байгууллагын www.cd.gov.mn, www.shilendans.gov.mn сайтад хуулийн хугацаанд буюу 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тус тус байршуулсан.</p> <p>Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлэх ажлын төлөвлөгөөг батлан, төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам хянан нэгтгэж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлсэн ба аудитын байгууллагын акт, дүгнэлтийг байгууллагын www.cd.gov.mn сайтад байршуулсан.</p> <p>2018 онд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 13 тендерийг нээлттэй зохион байгуулж, тендерийн урилгыг өдөр тутмын сонин, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn, байгууллагын www.cd.gov.mn сайтад тус тус байршуулсан ба тендерүүдийн үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтад мэдээлж, гэрээний хугацаанд хэрэгжүүлж дууссан.</p>
<p>21.</p>	<p>4.21.1. Бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах зарыг цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.</p> <p>4.21.2 Худалдан авах үйл ажиллагааны тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн</p>	<p>13 тендерийг нээлттэй зохион байгуулж, тендерийн урилгыг өдөр тутмын сонин, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn, байгууллагын www.cd.gov.mn сайтад тус тус байршуулан мэдээлсэн.</p> <p>Нээлттэй зохион байгуулж буй тендерийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн</p>

	танилцах боломжоор хангах	шилжүүлэх, Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах.	ахлах мэргэжилтэн болон Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төрийн бус байгууллагын хоёр төлөөллийг оролцуулан ажилласан.
--	---------------------------	--	--

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР